

ЛАЛЖААГҮЙ ЛАЛЫН ИРАНД ЗОРЧСОН МИНЬ

*Д.Баярхүү**

Судлаач профессор, дипломатч, Монгол Улсаас АНБЕУ-д суугаа Элчин сайд Д.Баярхүү нь 2010 оны 11 дүгээр сард Тегеран хотноо Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээний Сайд нарын IX уулзалтад Засгийн газраа төлөөлөн оролцох далимдаа тэр орны талаар тэмдэглэл хөтөлж түүнээ сийрүүлж тус сэтгүүлийн уншигчдад сонирхуулъя хэмээн шийджээ. Тэрээр Каираас Иранд хавсран суухаар болж байгаа тул тэр орныг гүнзгий таньж мэдэх ёстой хэмээн үзэж байгааг нь сэтгүүлийн зөвлөл дор хуваалцлаа.

Нэг. Иран руу эргэлтгүй татагдах шалтаг шалтгаан

Ер нь Иранд очиж үзье гэх санаа надад аль дээр үед төрсөн юм. Түүхийн ном зохиол сөхөж үзэж байхад Монгол-Персийн харилцааны тухай түүхэн баримтууд нэлээд тааралддаг. 1237 онд анх монголчууд тэр орныг дайлаар мордож, сүүлд нь найрамдан энхийн гэрээ байгуулж байсан ба дараахан нь Монголын хааны элчийг Персийн шах нь цаазалсанаас үүдэн дахин дайтаж персүүд үхлээ өөртөө дуудсаны гайгаар эзлэгдэж тусгаар тогтнолоо алдаж байсан тухай ираны түүхч доктор Али Рахимпур бичсэн нь бий. Түүний номд бичсэнээр бол Хүлэг хаанаас түүчээлэн 1272-1377 онд 105 жил Монголын 17 хаан (Илхаад) Персийг захирч байжээ. Бүхэл бүтэн зуун жил монголчууд Ираныг захирч байж шүү дээ гэхлээр тэр орон руу ямар ч монгол хүн татагдаж сонирхох нь зүй юм. Монголчууд Ираныг захирч байснаас үүдэлтэй түүхэн шалтгаан бол энэ болов уу.

Угсаатны талаасаа ямар ч монгол хүн татагдахаар бас нэг шалтгаан байна. Энэ чинь хэнсэн билээ гэж андуурмаар монголжуу, хөрслөг бор царайтай онигор нүдтэй хүмүүс Тегеранд зөндөө тааралдаж байсан нь монголын дайнчдын удам хазарууд (хазар - azfpa) хэмээн Иранд үздэг аж. Тэд лалжаад, перс-тажик хэлийг өөриймшүүлж авчээ. Эрчүүд нь толгой дараалан Чингис нэртэй монголжуу тосгон Тегераны ойролцоо бий хэмээн тийшээ очоод ирсэн манай албаны нэг нөхөр ярьж байсныг би сайн санаж байна. Болдогсон бол очиж үзмээр л санагдаж байна.

“Манай зууны хөрөг” номыг Баабар бид хоёр 1997 онд хамтран бүтээхдээ Ираны лалын хувьсгалын удирдагч Аятолла Хомейнийн улс төрийн хөргийг гаргах гэж орчин үеийн Ираны түүх рүү нэлээд хальж орсон. Тэр маань ч Иранд очиж үзье гэх санааг минь үлэмж хурцалсан.

* Д.Баярхүү - Монгол Улсаас АНБЕУ-д суугаа Элчин сайд, дипломатч, судлаач профессор

Арваад жилийн тэртээ би Энэтхэгт алба хашиж байхдаа Иранд очих хүсэлдээ хөтлөгдөх нэгэн үйл явдал болсныг сайн санаж байна. Юу гэвэл бид 1999 оны зун Хималайн энгэрт үүлэн дунд байрлах Нанитал хэмээх хотод уригдчихаад Нью Дели руу буцах зам зуураа Рампур хэмээх жижиг хотод саатаж, Рампурын эртний номын санд хөл тавих их хувь тохиосон юм. Моголын хаадын үед л тийш нь аваачсан очсон болов уу, нөгөө түүхийн алдарт хөлгөн судар “Судрын чуулган” чинь бүрэн эхээрээ перс хэл дээр тэнд хадгалагдаж байх юм аа. Тэр аугаа бүтээлд гар хүрч, долоох нь холгүй хуудсыг нь эргүүлж, адис авч, тэргүүндээ хүргэсэн тоотой хэдхэн монголын нэг нь би болсноо нэгэн насны бахархал гэж үздэг юм.

Ираныг сонирхох бас нэг шалтгаан, магадгүй гол шалтгаан нь миний мэргэжил, судалгааны ажилтай холбоотой. Миний бие “Евразийн геополитик, олон улсын харилцаа: Өнгөрсөн, одоо, ирээдүй”, “Геополитикийн лекцүүд” зэрэг судалгааны зохиолууддаа Ираны геополитикийн хувьсал, хэтийн төлвийн талаар нэлээд дэлгэрэнгүй бичиж, тэр хэрээрээ тэр орныг сонирхох болсон. Чингэхдээ америк профессор С.Хантингтон, З.Бжезински, Оросын философич А.Дугин, эрдэмтэн В.А.Русаков, футурлогч В.Феллер нарын зохиолоос эшлэж, XXI зууны дэлхийн хөгжил, дэлхийн бодлогод Ираны гүйцэтгэх үүргийг урьдчилсан төсөөлөхийг хичээсэн. Лалын маш хүчтэй иргэншил бүхий Иран төвтэй хүчний төв бүрэлдэж буй тухай тэд нэгэн зэрэг шахуу тэмдэглэсэн байдаг юм билээ. Үүний үнэн мөнийг очин байж нүдээрээ үзэж, биеэрээ мэдрэе гэх бодол олон жилийн өмнөөс намайг тийш нь татан дагуулсан гэх үү дээ.

Хоёр. Би энэ оронтой эргэлтгүй холбогдов

Намайг энэ Каираас Иранд хавсран суулгахаар Ерөнхийлөгчийн зарлиг гарч буй тул Иран орон яалт ч үгүй надад хамгийн ойр байхаас аргагүй болж байна.

Монгол-Ираны орчин үеийн харилцааны түүх гэвэл сонирхол татахаар ч гэдэг юм уу, тоймтой юм нэг их байхгүй. Манай улс Лалын Бүгд Найрамдах Иран Улстай 1971 онд дипломат харилцаа тогтоогоод 10 хүрэхгүй жил улс төрийн харилцаа хөгжүүлэх чиглэлээр ажиллаж ирсэн байдаг юм. 1973 онд Монгол Улсын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал Иранд, 1976 онд Ираны Ерөнхий сайд А.Ховейда Монголд харилцан айлчилсан байдаг. Сонирхуулахад социализмын үед ач буянаа харамгүй өгсөн Хүүхдийн төлөө фонд гэдэг чинь Ираны хур туршлагаар анхлан боссон юм билээ. Энэ тухай Баабар “Монголчууд” хэмээх номдоо тод томруун бичсэн нь бий. Чухамдаа Цэдэнбалтай 1973 онд Иранд айлчилснаар Филатова Шахын тансаг хатан Фарахын толгойлдог хүүхдийн фондын үйл ажиллагаатай танилцаж, ийнхүү Филатова Иранаас бөөн туршлагатай ирэв ээ гээд байж байгаа.

Иранд лалын хувьсгал ялснаар манай хоёр орны харилцаа зогсонги байдалд орж, Иран-Иракийн дайн, Ираны дотоодын адармаатай улс төрийн нөхцөл байдал ч харилцаанд үлэмж саад болсон байх.

Иран орон дотооддоо тогтворжин бэхжихийн хэрээр хоёр талын харилцааг нөгөө талаас сонирхох байдал ажиглагдаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нар 2004, 2005 онд Ираны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч нартай олон улсын хурал чуулганы үеэр уулзаж, тухайлбал 2005 оны 10 дугаар сард болсон ШХАБ-ын Засгийн газрын тэргүүн нарын уулзалтын үеэр Ерөнхий сайд Ц.Элбэгдорж Ираны Дэд ерөнхийлөгчтэй уулзаж хоёр орны харилцааны асуудлаар санал солилцож, Ирантай газрын тос, боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр хамтын ажиллагаа хөгжүүлэх, оюутан сургах, манай эрдэмтэн судлаачдыг Иранд илгээж Монголын түүхийн холбогдолтой перс хэл дээрхи эх сурвалжуудыг судлуулах сонирхлоо илэрхийлсэн нь харилцааг түлхүү ахиулахад чиглэсэн анхны шижим болсон гэж үзэж болох үндэстэй.

Монгол-Ираны орчин үеийн харилцааны түүхийг бичилцэх хувь надад ногдож, тэр орныг очиж үзэх хүсэл минь гүйцэлдэх анхны учрал 2009 оны намар надад тохиов. Тегеран хотноо Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээний Сайд нарын IX уулзалтад Засгийн газраа төлөөлөн оролцов.

ЛБНИУ-ын Ерөнхийлөгч Махмуд Ахмединежадын Сайд нарын тэр уулзалтыг нээж хэлсэн үгнээс миний тэмдэглэж авсныг сонирхуулъя. Тэрээр манай хуралд хүндэт зочноор уригдсан юм. Дэлхийн дэг журмыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай болсон өнөө үед Ази тивийн улс орнуудын хамтын ажиллагаа, нөхөрлөл амин чухал бөгөөд дэлхийг хамарсан асуудлуудыг Азийн орнууд оролцож шийдвэрлэж байдаг тийм шинэ механизмийг бий болгохын төлөө бид ажиллах хэрэгтэй гэсээр тэрээр үгээ эхэлж байв. АНУ ба өрнийхнийг Азид гай гамшиг, үхэл зовлон, дайн дажин авчирдаг хэмээн түүхэн баримтаар буруутгаад дэлхийн хоёр их дайн, Солонгосын дайн, Вьетнамын дайн, Афганистаны дайн, Иракийн дайн, Израиль-Палестины мөргөлдөөнийг жишээ болгож ярих. Дэлхийн шинэ дэг журам зайлшгүй, харин тэр нь хүндэтгэл, шударга ёсонд тулгуурласан байвал зохино гэж тэрээр мэдэгдэв. Азийн улс орнуудын хамтын ажиллагаа, нөхөрлөл гэдэг ерөнхий жанжин шугамынхаа хүрээнд манай улсыг авч үзэж байгаа нь ч дараа нь намайг Ираны ГХЯ-нд урьж уулзах үед тэдний албаны хүмүүсийн ярианаас илт мэдрэгдэж байв.

Гурав. Лалын шашинжсан орон биш болж таарлаа

Иран гэхлээр манайханд ерөнхий, нийтлэг нэг тийм ойлголт байдаг байх. Би ч бас яг тийм ойлголттой “Хомейни олон улсын

аэропорт” дээр нь газардсан юм. Дэлхийн хамгийн, хамгийн биш юм аа гэхэд хамгийнүүдын нэг болох шашинжсан лаллаг (лалын шашинт) улсад хөл тавилаа даа гэж төсөөлж байв. Харин очсон даруйдаа “Энэ чинь лалын шашинжсан орон мөн гэж үү?” гэх хачин асуулт өөрийн эрхгүй намайг ороогоод авлаа. Нөгөө нойрон дунд үүр шөнөөр “Аллах Акбар” (“Аллах аугаа”) гээд л мөргөлийн дуу цонхны шил доргитол хадаад унадаг нь Тегеранд сонсогдсонгүй юу, эсвэл би андуурав уу, бүр гайхаад зочид буудлынхаа тагтан дээр гарч харлаа. Манай Каиртай зүйрлүүлэхэд сүм мечет, мөргөлийн газар нь ч Тегеранд хамаагүй цөөн юм. Гэхдээ тоолсон биш, хаа нэг харагдаж байна лээ.

Дэлхийн хэвлэлд бичдэг, зурагтаар харуулдагаар бол хар жанч нөмөрсөн, сахал үсэндээ баригдсан имам, мулла, муфтий нар гудамж талбайгаар нь дүүрэн хөлхөж явдаг юм болов уу гэсэн нь лав надтай тааралдсангүй. Ганц нэг байх нь байлгүй яахав.

Барууныхны бичдэг ярьдаг бас нэг сэдэв байна. Эмэгтэйчүүдийн эрхийг айхтар хөсөрдүүлдэг, тэд нь ч нуль хар гивлүүр нөмрөг, хүний өөдөөс эгцэлж харахгүй шахам явдаг юм болов уу гэтэл бас тийм биш. Охид бүсгүйчүүл нь толгой нүцгэн явж л болохгүй, түүнээс бус доогуураа юу, ямар өнгөтэй юм өмсөж зүүх нь чөлөөтэй, бүр жийнс өмссөн охид маш их байна гээч. Мэдээж мини банзал болохгүй л дээ. Өвдөг шилбээ ил харуулах нь лалын номд хориотой. Перс айлд бэр орсон нэгэн монгол бүсгүй Б.Мөнгөнчимэгийг сурагласаар гэрт нь очлоо. Тэр айлд шашны албадлага, мухар сүсэг ер алга. Тэр бүсгүй жаргалтай аж төрж байна. Шашны элдэв дарамтад орж үзээгүй, перс нөхөр нь дарамталдаггүй, гадагш гарвал алчуур л зүүдэг, өөрөөр яадаг ч үгүй гэж байна. Улаанбаатараас аав нь зочлоод оччихсон, биднийг найрсгаар угтаж нэг оройг хамт өнгөрөөв. Гэм нь Иранд архи дарс даан ч хориотой юм. Гэм нь лгээ дээ, монголчууддаа хандаж бичиж байгаа учраас тэгж байна.

Манай Египетэд бол (ялангуяа хөдөөд нь) духаа цоортол мөргөөд дух нь сорвижоод эвэршчихсэн эрчүүд захаас аван таардаг бол Иранд ийм эрчүүдийг би хэд хонохдоо олж харсангүй. Мөргөдөг нь мөргөдөг л байх. Гэхдээ хэтрүүлдэггүй юм болов уу гэж таамаглав. Саудын Арабт мөргөлийн цаг болохлоор бүх ажлаа зогсоогоод албан газрууд нь хаалгаа бариад, лал бусчуудыг номхон зогсоох нь холгүй хүндэтгүүлж байгаад мөргөлөө үйлддэг бол Тегеранд хэд хонохдоо тийм зуршлыг би олж харсангүй. Мөргөлийн ид цагаар албан ажил нь овозлож хүмүүс нь холхиж, хийх юмаа хийж байна. Сэтгэлдээ залбираад амандаа мааниа уншаад явдаг хэмээн надад нэг нөхөр хэлж байна лээ. Тэр үнэн байх.

Шашны фанатизм гэх юмыг би лав ил олж харсангүй. Буцах өдрөө хэргээр Хомейнийн бунханд зочилсон юм. Тэр нь Тегеран хот, Хомейни олон улсын аэропорт хоёрын замын яг дунд байрладаг тул дайраад гарахаар шийдлээ. Сөхөрч мөргөсөн, уйлж унжсан, нүглээ наминчилсан

сүрэг хүнтэй таарна гэж бодсон чинь бас тэнд нь алга, нам жим. Шарил нь ногоон хамба хилэнгээр хучигдаад маш том шилэн хоргонд байж байна. Тэр нь маш том мечет дотор байна. Тэр ариун дагшин газрыг би бол мөргөлийн сүм, Хомейнийн бунхан гэхээсээ илүүтэй түүх-соёлын том цогцолбор, уран барилгын хосгүй бүтээл хэмээн нэрлэмээр санагдлаа. Иранчууд тэнд эхнэр хүүхдээ дагуулаад гэр бүлээрээ аялаж зугаалж, тэр том сүмд их аятоллатайгаа зэрэгцээд унтаж амарч, идэж ууж хөөрөлдөж хөгжилдөж байхыг хараад гайхлаа. Алжаал тайлдаг газар ч юм уу?

Имам Хомейнийн бунханд зочилсон монгол хүн гарын арван хуруунд багтах төдийд байдаг бол би бас тэр ховор учралыг амссан нэг нь болж таарна хэмээн бэлгэшээж сууна. Тегеран хотоос чанх баруун өмнө зүгт Бехеште-Захра хэмээх оршуулгын газар байгуулсан энэхүү мечет бол 91 метр өндөртэй 4 лут минаретаар (цамхаг гээ) хүрээлэгдсэн аварга том барилгын цогцолбор аж. Баруун өмнө зүгт гэдэг нь нөгөө ариун дагшин Меккаг (Саудын Араб) чиглүүлж байршуулсан, мөн л исламын шашны бэлгэдэлийн илэрхийлэл гэнэ.

Дөрөв. Дэлхийн хамгийн аугаа шашнуудын өлгий нутаг

Шашин гэснээс би учиргүй лалжсан зүйл нүдэнд ил харагдсангүй гэсэн, түүн рүүгээ дахин орж тайлбар хайя. Иран бол зороастрын (зороастризм) шашны өлгий нутаг бөгөөд тийм шашинтай явж байгаад бүр хожуу XVI зуунд лалын шиитийн урсгалыг төрийн шашин болгосон юм билээ. Иран өөрөө эртний улс, анхны төр улс Элам гэдэг нь манай эриний өмнөх III зуунд Хузестанд бий болсон, анхдугаар Дарии хааны үед Персийн хаант улсыг тэд байгуулаад Грекээс Инд мөрнийг хүртэлх асар удам нутгийг захирч байсан, өөрсдийнх нь бахархдагаар бол дэлхий дээр 2500 жил тасралтгүй оршин тогтнож буй цорын ганц улс гээд тооцож үзэхүл ислам нь Ираны түүхэнд бага зай (500 жил орчим) эзлэх мэт. Үлдэх 2000 жилд нь “Зороастризм”-тайгаа байсан ба тэр шашнаа хүн төрөлхтөний анхны суурь шашин гэж өөрсдөө үздэг, түүх ч тэгж нотолдог юм байна.

Зөнч биваагарьд Заратуштра энэ шашныг үндэслэсэн, бурханаас түүнд Ахура Мазды гэж нэр хайрласан, мөн чанар нь ариун сэтгэл, ариун үйлсийн төлөө өөрийн сонголтоор амь биеэ үл хайрлахыг номлодог, бурхан амилаад газарт буугаад ирсэн нь тэр хэмээн галыг сүсэглэдэг шашин аж. Одоо Иран, Энэтхэгт энэ шашны голомт байна. Зороастраас христос, жүүд, лалын шашнууд салбарлаж төрсөн бөгөөд үнэхээр цаг хугацаагаар нь хөөж үзвэл энэ гурав бол дэлхийн дараагийн гол шашнууд болж таарч байна. Энэ гурав дээр суурилаж хүн төрөлхтөний иргэншил соёл хөгжсөн гэдэгт иранчууд гүн итгэдэг. Тэгээд ч Грек (цаашаа Европ), Турк, Араб, Энэтхэгийн иргэншилд Ираны нөлөө маш их байсан хэмээн тэд бахархдаг.

Дэлхийд гурван шашин байна, тэр нь христос, жүүд, лал хэмээн Египетэд олон хүн үздэг юм билээ. Ираны шашны тайлбар ч үүнтэй төстэй юм шиг. Тэгвэл манай бурхан будда чинь юу болж таарах вэ хэмээн би мөн ч олон удаа маргаж, амаа таглуулсан даа. Хариулт нь тодорхой. Амьд явсан бие хүнд (Будда) бид шүтэж сүсэглэж байвал тэр нь шашин биш, харин Будда нь өөрөө бурханы элч болж бурханы үгийг номлож байвал тэр нь шашин мөн гэх тайлбарыг бишгүй нэг сонсож байна. Аллах бол бурхан, тэр мөнхөд оршино, түүнийг хэн ч төсөөлж зүрхлэхгүй, харин зөнч Мухаммед бол Аллахын дэлхийд илгээсэн цорын ганц элч нь, энэчлэн нигүүлсэгч Исүс Христос бол мөн Ертөнцийн эзний элч нь, Ертөнцийн эзэн бол мөнх гэж тайлбарладаг. Тэгвэл тэр цаад бурхан гэдэг нь Заратуштра гэдэг тэр зөнчийг элчээрээ дэлхий рүү анхлан илгээсэн гэж Иранд үздэг юм байна.

Учиргүй лалжаагүй гэдгийг нь илтгэх гайхалтай баримт Иранд байх юм аа. Лалын тэр их хатуу бодлоготой улсад лалаас гадна гурван шашин: христосын, жүүдийн, зороастризм хуулиар хамгаалагддаг, Үндсэн хуульдаа тусгайлсан заалттай. Бусад шашнууд бол (буддын, бахай, хиндү гэх мэт бусад бүгд) хуулийн этгээд биш, харин нэр бүхий эхний 4 шашнууд нь парламентад төлөөлөлтэй байх эрхтэй, тэгээд ч жүүд (еврей) депутатууд хүртэл их хуралд нь хэд хэдээрээ бий гэж байна.

Тав. Иран ба Жүүд

Энд толгой эргүүлмээр баримт дурдагдаж байна. Жүүдийн төр улсыг газрын хөрснөөс арчиж хаяна, нацистууд II дайны үед жүүдүүдийг аймаглан устгасан, холокаст энэ тэр гэдэг чинь шал зохиомол хэмээн Махмуд Ахмадинежад гуай айлдаад байсан атал еврейчүүдтэй (тэд хэдий цөөхүүлээ ч гэсэн) төрөө хуваалцан барилцаж байна, бүр Тегеранд нь 20 синагог (еврейн сүм) ажиллаж байна гэдэг анхандаа надад төсөөлөгдөхгүй байлаа.

Бас нэг хөндлөнгийн тайлбарыг сонирхъя. Хэн гуай ч интернэтээс өлхөн олоод үзчих мэдээлэл л дээ. Ахмадинежад гуайн тэгж ярьсан нь бүр шал өөр зорилготой хэмээн британийн Дейли Телеграф агентлаг таамаглал дэвшүүлжээ. Албан ёсны намтраараа бол тэрээр Ираны Семнан мужийн Арадан тосгонд 1956 онд төрсөн. Гарал үүслийг нь нэг их дурддаггүй. Албан ёсоор бол перс л гэх байх, харин азербайжан, тальш гэх мэтээр гадаадын хэвлэлүүд бичсэнийг интернэтээс харчихаж болно. Гитлерийн өвөг эцэг нь жүүд байж, тэднийхэн хэдэн үеэрээ гадуурхагдсанаас болоод тэрээр жүүдүүдээ үзэн ядаж өссөн хэмээн саяхан Оросын ТВЦ нэвтрүүлгээр нэг удаа таамагласан шиг Ираны одоогийн Төрийн тэргүүн бол жүүд, жинхэнэ нэр нь Сабурижиан, энэ бол Ираны жүүдүүдийн түгээмэл нэр, эцэг эх нь лалд орохдоо овгийн нэрээ өөрчилсөн хэмээн Дейли Телеграфын мэдээнд (The Telegraph, 3 Oct 2009) нотлохыг

зорьжээ. Жүүд гэдгээ нуухын тулд Израилийг харааж зүхэж дүр эсгэдэг хэмээн цааш нь бичсэн байх юм. Гэтэл “Гардиан” сонинд (The Guardian, 5 October 2009) үүнийг сэргүүлж, тэр бол жүүд огтоос биш хэмээн Ойрхи Дорнодоор мэргэжсэн Меир Жавенданфар гэгч бичээд, энэ бол ердөө л бор шувуу, аман салхи (цуурхал гэсэн санаа нь тэр юм болов уу) гэж бүр цохон тэмдэглэсэн байх аж. Жүүдүүдтэй төрөө хуваалцан бариллаж байна, Тегеранд нь олон синагог идэвхтэй ажиллаж байна, жүүдүүд нь Үндсэн хуулиараа хамгаалагддаг юм байна гэдэгт гадаадынхан тайлбар хайж байгаа нь л энэ юм болов уу. Энд би ямар нэг зүйл нотлохыг зорьсонгүй, энэ бол миний байр суурь огтоос биш, дэлхийн хэвлэл мэдээллийн нэгээхэн таамгийг эшлэж байгаа хэрэг юм шүү дээ.

Зургаа. Монголчуудад илүү ойр байж мэдэх иргэншил, соёл, орчин

Ер нь Тегеранд очоод төрсөн миний анхны сэтгэгдэл бол энэ хот яв ч лалын, арабын, дорно дахины хот биш юм, үндэстэн угсаатан, шашин-соёлын хувьд маш өвөрмөц хот юм гэж ойлгосон, элдэв юм унших тусам тэр нь бүр нотлогдож байна. Дүүрэг хотуудыг нь оролцуулаад “Их Тегеран” гэж нэрлэх ба нийт оршин суугч нь 13 саяас давж байгаа, энэ үзүүлэлтээр бол Азийн томхон хотын тоонд зүй ёсоор орно. Хотын гудамжаар нь өдөр шөнөгүй давхиж явахад харьцуулалт хийх элдэв зүйл надад бишгүй ажиглагдаж байлаа. Дэлхийн аль хоттой төсвтэй вэ гэдэгт элдэв хариулт ч олж болохоор. Тэр их даваа гүвээгээр өгсөж уруудаж явахдаа уул толгодыг дамнуулан байгуулсан Белград, Стамбул, Софитой ч төстэй юм болов уу гэж бодож байв. Иран бол ерөнхийдөө уулархаг орон юм уу даа. Тегераны тэр их гүүрэн замууд, хоёр талаар хяр дээгүүр эгнэх шинэ хорооллууд бол яалт ч үгүй Стамбулыг санагдуулам. Битүү модон дундахи дан, давхар байшингууд, хуучны хашаа хэрэм нь Алматы хотын хуучин хорооллыг санагдуулам. Хуучны цайз бэхлэлт, барилгын зарим дизайн нь Баку хотын захын хорооллыг санагдуулам. Хотын чанх хойно өндөр уулс сүглийх нь 4 уулаар хүрээлэгдсэн нийслэл хотыг маань ч санагдуулах шиг. Хэрэв оройд нь цас цайран харагддаггүй бол Далан хар уулын өвөрт орших Хөх хотын хойд этгээд яг тэгж харагддаг даа ч гэж харьцуулан бодов.

Ерөнхийдөө европ маягийн хот юм. Байшин барилга нь европ ур хийцийнх зонхилж байна. Хот байгуулалт, зам харгуй, цэцэрлэг нь ч хуучны Европыг санагдуулам. Энэ утгаар би Тегераныг лалын, арабын, дорно дахины хот биш гээд байгаа хэрэг. “Тегеран-43” гээд ном зохиол, кино, дурсамж бишгүй нэг бий дээ. Нацистын Германы эсрэг их эвслийн дээд хэмжээний уулзалт болж, XX зууны түүхийг бичилцсэн гурван их удирдагч очиж байсан хот гэхлээр яалт ч үгүй дэлхийн түүхнээ нэрээ мөнхөлсөн хот болж таарна. Түүхэн гэдэг утгаараа.

Иран нь 60 гаруй үндэстэн ястан, отог омгоос бүрдсэн олон үндэстний орон юм. Гэхдээ перс, түрэг гэсэн үндэстний хоёр том бүлэг зонхилж байна. Перс гэдэгт персүүд, ялангуяа хотын хүн амын олонхи нь, перстэй төстэй, төсвтэйвтэр гэдэгт гилиан, мазендеран, талыш, курд, лур, бахтиар, пуштун, белуж, тажикууд, харин түрэг гэдэгт азербайжанууд ордог юм байна. Иранчуудыг гаднаас нь хараад нэлээд европжсон, соёлжингүй улс юм уу гэсэн сэтгэдэл төрж байлаа. Тэдний аж төрөл, соёл, хоол хүнс нь, хот байгуулалт, цаг агаар нь арабтай харьцуулахад монголчуудад илүү ойр байж мэдэхээр ч санагдсан.

Тегеранд Азид томхонд орох зах байдаг гэсэн, өөрсдөө ч их ярих юм, очиж үзээгүй. Харин очиж үзүүштэй дурсгалтай нэгэн газар байнаа. Зам дагуу юм. Зардал чирэгдэл орохгүйгээр гуравхан ам. доллараар (30 мянган иран риал) үзчихэж болно. 1971 онд Ираны хаант ёсны 2500 жилийн ойгоор босгосон гэж байна. Эрх чөлөөний цамхаг – Азади тауэр. Ираны тухай гадаадын ТВ-үүдийн мэдээнд байнга гаргадаг даа, 4 тийшээ алцалгаж босгосон тэгш оройтой, шаргал өнгөтэй, том арктай хөшөөрхүү барилга байдаг. Түүний орой дээрээс Тегеран хот тэр чигээрээ хэдэн тийшээ харагдаж байна лээ. Тэнгэр цэлмэг бол түүний орой дээрээс хичнээн гоё кино-фото зураг авч болох бол доо хэмээн бодож байлаа. 2007 онд Тегераны төв хэсэгт, гэхдээ өндөрлөг газар Бурже Милад хэмээх 435 метр өндөр (дэлхийд 4 дүгээрт орох) телецамхаг босгожээ. Бид дэргэдүүр нь бишгүй нэг давхиж явсан даа.

Долоо. Хүчирхэг эдийн засгийг босгожээ

Ажаад байхад Иран нь хөгжлийн дардан замаар жирийлгээд өнөөгийнхөө өндөрлөгт хүрчихээгүй юм билээ. Энэ талаар баримт сөхөж ажиглалт дүгнэлт хийснээ уншигчиддаа сонирхуулъя.

Ираны хөгжил дэвшил 1978-1979 оны лалын хувьсгалаар нэг саатаж зогсоод, дараа нь Иран-Иракийн дайны балаг сүрхий нөлөөлж, 1990-ээд оноос хөгжил нь жигдрээд, одоо бол сэргэлт явагдаж байна хэмээн үздэг.

Шинэ зуун гараад аялал жуулчлал бүрэн сэргэжээ. Шинэ зууны эхээр жилдээ жуулчны 300 мянган виз олгож, 2004 он гэхэд 1.7 сая гадаадын жуулчин хүлээн авч байж. Хэдэн жилийн өмнө жуулчлалаас 2 тэрбум ам.долларын орлого олсон гэж байна. Хилийн боомтууд дээр жуулчны виз шууд олгодог нь ч ихээхэн хөнгөлөлт болжээ. Виз олгоход ямар ч саад байхгүй, хил дээр 70 ам.доллар төлөөд хэн бэ гуай ч хоёр 7 хоногийн виз авч болно хэмээн ГХЯ-ных нь албаны хүн ярьж байсан. Мөн интернэтээр анкет бөглөөд онлайн виз авчихаж болох юм билээ.

Гадаадын жуулчдын ихэнхи нь хөрш лалын орнуудын мөргөлчид байсан бол бүтэц нь аажмаар өөрчлөгдөж байна. Лалын жуулчид Мешхед, Кум хот, Хомейнийн бунхан руу зүглэдэг бол европын жуулчид археологийн олдвор, хуучны уран барилга, туурь цайз,

музейд нь татагддаг ба Иранд жуулчдыг татан дууддаг түүхэн, дагшин газар 68 байдаг аж. Египеттэй харьцуулахад Иранд групп жуулчлал (багийн) төдийлөн хөгжөөгүй, харин бие дааж амь амиа бодсон жуулчид гэр бүлээрээ, ганц нэгээрээ очих нь түгээмэл байх шиг.

Жуулчлал эрчтэй хөгжихгүй байх шалтгаан нь дэд бүтэц султайнх гэж өөрсдөө тайлбарладаг. Хүн амынх нь 1.8 хувь жуулчны бизнес эрхэлдэг гэхлээр нийт хүн амд нь хуваагаад үзвэл (74 саяын 1.8 хувь) үнэхээр чамлалттай. Хэдийгээр ойрын жилүүдэд жуулчлалын бизнесийг 10 хувиар өсгөнө гэсэн бодлого барьж байгаа ч лалын хувьсгалын мөн чанар, лалын хувьсгалын сургаалиас үүдэлтэй, өрнөдийнхний эсрэг хатуу байр суурь нь энэ салбарын бизнесийг чөдөрлөж байх талтай. Эмэгтэйчүүдийн хувцаслалтад тогтоосон жишиг, исламын ёс жаягийг зөрчвөл гадаадын хэн бэ гуайг ч цээрлүүлчихдэг (ер нь Иранд гэмт хэрэгтнийг маш хатуу цээрлүүлдэг) зэргээс үүдээд гадаадын жуулчид тийшээ тэгтлээ цувахгүй байж болох юм.

Аялал жуулчлал бол улс орны тэргүүлэх салбар байж, тэр нь орчин үеийн стандартаар, хэрэг дээрээ барууны стандартаар хөгжиж байж л үр дүнд хүрэх учиртай. Аялал жуулчлалын гол нөхцөл нь зочид буудлын бизнес байдаг. Тегеранд бидний буусан Parsian Esteghlal International Hotel гэдгээр жишээ авч болохоор. Уг нь 1979 оны хувьсгалаас өмнө Hilton зочид буудал байсныг хувьсгалчид нийгэмчлээд нэрийг нь өөрчлөөд “Тусгаар тогтнол” болгочихож, Esteghlal гэдэг нь перс хэлээр тусгаар тогтнол гэсэн үг юм байна. Ингээд Hilton-ыг Esteghlal-аар солиод, менежментийг нь өөрчлөөд лалжуулаад, хувьсгалжуулчихаж. Таван одтой гэхэд бусад орны ийм зэрэглэлийн буудлын дэргэд (би бол Hilton-той нь харьцуулмаар санагдлаа) үйлчилгээ нь эрс ялгарч байна лээ. Адаглаад л бялдаржуулах танхим, усан сан нь төд дэх өдөр эрчүүдэд, төд дэх эмэгтэйчүүдэд үйлчилнэ гэсэн хатуу журамтай. Өглөө эрт онгойно гэж байхгүй. Сархадыг хорьсноос үүдэн баар, ресторан гэхээр юм байхгүй, ингээд өөлөөд байвал монголчуудад төсөөлөгдөмгүй. Энэ ч яахав, гол биш. Цаг хугацааны асуудал.

Ираны жин нөлөө, Иран дэлхийд ер нь хэн юм бэ гэдэг талаас нь бичвэл уншигчдад сонин байж магад. Иран бол нутаг дэвсгэрийнхээ хэмжээгээр манайхаас том (1.648 сая хавтгай дөрвөлжин км, Европтой харьцуулж үзвэл, тэр чигтээ Британи, Испани, Франц, Итали ба Швейцарийг нийлүүлээд байж байна гэсэн үг), стратегийн болон геополитикийн маш ашигтай, чухал байршилтай орон юм. Каспийг Персийн булантай холбох хуурай газрын цорын ганц гарц Иранд л байна. Өмнөөс хойшоо гэсэн тэнхлэг дээр ийм давуу талтай юм гэхэд баруунаас зүүн гэсэн тэнхлэг дээр Турк, Ойрхи Дорнодыг Төв Азитай холбох хуурай газрын гарц бас тэнд байна. Хэрэв Турк нь Европын Холбоонд нэгдчихвэл (цаг хугацааны асуудал л үлдсэн) газар зүйн хувьд

Еврази нь Иран-Туркээр зааглагдаж, Азийн баруун хязгаар нь Иран болох мэт төсөөлөгддөг юм.

Хүн амын өсөлтөөр (эдүгээ 74 сая) байнга тэргүүлж байна. 1979 оноос хойш хүн ам нь хоёр дахин өссөн. Энэ бол хүний хүчин зүйл, хүний нөөц гэдэг утгаараа тэр орны том давуу тал юм.

Эдийн засгийн талаасаа бол Иран нь үндэсний үйлдвэрлэлээр дэлхийд 15 дугаарт, эдийн засгийн гол гол үзүүлэлтээр дэлхийд 16 дугаарт яваа, Баруун Ази, лалын ертөнцөд Турктэй зэрэгцэх (2007 дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр Туркийг ардаа орхисон, 852.6 тэрбум ам.доллар), бүс нутагтаа бол технологийн хувьд үлэмж хөгжсөн орны тоонд зүй ёсоор орж байна. Ази тивээр авч үзвэл Иран нь ДНБ-ний хэмжээгээр Япон, Хятад, Энэтхэг, Өмнөд Солонгосын дараа орж байна.

Газрын тос, байгалийн хийн нөөцөөрөө Евразидаа дээгүүрт орно. Нефть экспортлогч орнуудын байгууллагын (ОПЕК) гишүүд дотор нефть олборлолтоор Саудын Арабын дараа хоёрдугаарт, нефть экспортоор 4 дүгээрт явж байгаа. Дэлхийн зах зээлд 2000 оноос хойш нефтийн үнэ байнга өсч байгаа ба Иран үүнээс маш их ашиг олсон. Нефтийн нөөц нь 18 тэрбум тонн, дэлхийн нефть бүтээгдэхүүний худалдааны 5.5 хувь Иранд ногдог, хоногт 4.2 сая баррель олборлодог, түүнийхээ 2.7 саяыг экспортолдог гэхлээр бидний шагшаад байдаг Булангийн орнуудыг хэдийнээ ардаа орхисон мэт. Мөн дэлхийн байгалийн хийн нөөцийн 16 хувийг Иран эзэмшдэг ба энэ салбарт толгой цохих нь ойрын ирээдүйн асуудал юм.

Иран нь зөвхөн байгалийн баялгаараа эдийн засгаа босгодог гэж үзэх нь ерөөсгөл. 1970-аад оныг хүртэл Иран нь хөдөө аж ахуйн орон байсан юм билээ. Энэ байдлыг өөрчилж барууны, америкийн компаниудыг түлхүү оруулж аж үйлдвэржүүлэлтийг 1970-аад оны турш хийжээ. Дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах хэмжээний үйлдвэржүүлэлт явуулж, эдийн засгаа шинэчилж чаджээ. Харин сүүлийн үед эдийн засагтаа тэргүүлэх чиглэлийн салбарыг нь түлхүү хөгжүүлж байгаа. Энэ нь суурь машины ба автомашины, пуужин-сансрын, мэдээллийн технологийн үйлдвэрлэл гэнэ. Мэдээж уламжлалт – персийн алдарт хивсний үйлдвэрлэлээр толгой цохисоор ирсэн. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийг нь энд нарийвчлаад байх шаардлагагүй.

Шилжилтийн гэх бүлэг улс орнууд дэлхийн гуравны нэгээс давсан тухай “Хүйтэн дайн”-аас хойш бид бишгүй нэг ярьж байна. Ираныг эдийн засгийн талаас нь авч үзвэл яалт ч үгүй шилжилтийн орон гэхээр надад санагдлаа. Лалын хувьсгалаар нийгэмчилсэн салбаруудаа эргээд аажмаар хувьчилж байна. Төр мэдэх юмаа мэдэх нь зүй. Нефть-химийн үйлдвэр, эрчим хүч, хүнд машины үйлдвэр, банк, гадаад худалдаа, даатгал, мэдээлэл харилцаа холбоо, тээвэр, шуудан холбоо төрийн мэдэлд нэг хэсэгтээ байх нь зөв гэж тэд үзэж байгаа юм билээ. Харин

барилга, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, үйлчилгээний салбарыг хувьчилж дууссан гэж байна.

Найм. Нойрсож байгаа перс луу

Ямар ч атугай аль ч талаас нь аваад үзэхэд Иран нь ойрын ирээдүйд бүс нутгийн их гүрэн болох амбицтай гэдэг нь харагдсаар байна. Ираны өнөөгийн дэглэм олон улсын тавцанд хэрхэн авирлах нь тэдний өөрсдийнх нь хэрэг юм. Харин энэ дэглэм нэг өдөр солигдоход л дараа нь бүс нутагтаа цэцэглэн хөгжсөн, харьцангуй европжиж соёлжсон, хэтдээ өрнөдийнхөнтэй түншилж чадах бэлээхэн хөрстэй, нөлөө бүхий нэгэн гүрэн аажмаар төлөвшиж байна гэж үзэх үндэстэй юм. G-20, БРИК-т хэтдээ нэгдэх бүх нөхцөл нь тэр улсад аажмаар бүрдэж байна.

Биднийг Ливанд айлчилж явахад жижиг улс жижиг улсаа ойлгож дэмжих хэрэгтэй хэмээн улс төрчид нь бидэнд хэлж байсан шиг Ази тивийн улс орнуудын хамтын ажиллагаа, нөхөрлөл амин чухал бөгөөд Азийнхан бид бие биенээ дэмжих ёстой хэмээн Ираны удирдагчид байнга тэмдэглэх ажгуу. Намайг ГХЯ-ндаа хүлээн авч уулзсан *Зүүн Ази-Номхон далайн газрын Ерөнхий захирал нь дараахи саналыг тавьсан юм. Үүнд:*

- Бид Зүүн Азийн орнууд болох БНХАУ, ОХУ, Япон, БНСУ-тай маш сайхан харилцаатай. Монгол Улстай ч сайхан харилцаа тогтоохыг эрмэлзэж байна. Бид Монголд техникийн туслалцаа үзүүлэхэд бэлэн байна. Ялангуяа газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолт, зам, гүүр барих асуудлаар бид Монголд төсөл хэрэгжүүлж болох юм гэсэн юм.

Хэтдээ, тэгэхдээ нэг их холгүй дээ, бүс нутгийнхаа хүчирхэг гүрэн болох бүрэн магадлалтай энэ улсыг монголчууд бид анхаарлынхаа гадна үлдээж хэрхэвч болохгүй бөгөөд найрсаг харилцааны бодитой суурь, хамтын ажиллагааны оновчтой механизмыг эртнээс бодож, боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.